



**НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН
ХОРООНЫ ДАРГЫН ТУШААЛ**

2016 оны 12 сарын 06 өдөр

Дугаар А/76

Улаанбаатар хот

**“Улаанбаатар марафон-2016” олон улсын
гүйлтийн үеэр сургалтын төлбөрийн азын сугалаа
хожсон гүйгчдийн шагналыг олгох тухай**

Монгол Улсын “Биеийн тамир, спортын тухай” хууль, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Засгийн газрын 2009 оны 05, 2014 оны 34 дүгээр тогтоолууд, Нийслэлийн Засаг даргын 2016 оны А/51 дугаар захирамж, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн мөрийн хөтөлбөр, эдийн засаг, нийгмийн 2016 оны зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:


1. “Улаанбаатар марафон-2016” олон улсын гүйлтийн үеэр оюутны сургалтын төлбөр хожсон гүйгчдэд азын сугалааны шагналыг гардуулах арга хэмжээг 2016 оны 12 дугаар сарын 23-ны өдөр Улаанбаатар хотод зохион байгуулсугай.

2. “Улаанбаатар марафон-2016” олон улсын гүйлтийн үеэр оюутны сургалтын төлбөрийн азын сугалаа хожсон гүйгчдэд шагнал олгоход шаардагдах төсвийг нэгдүгээр, сургалтын төлбөрийн азын сугалаа хожсон гүйгчдийн нэрсийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Сургалтын төлбөрийн азын сугалаа хожсон гүйгчдийн шагнал олгоход шаардагдах 3.600.000 /гурван сая зургаан зуун мянган/ төгрөгийг Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хорооны биеийн тамирын арга хэмжээний зардлаас гаргахыг нягтлан бодогч /О.Эрдэнэцэцэг/-д зөвшөөрсүгэй.

4. Гүйлтийн үеэр оюутны сургалтын төлбөр хожсон гүйгчдийн азын сугалааны шагналыг олгох арга хэмжээг өндөр хэмжээнд явуулахыг мэргэжилтэн Б.Түвшинбаярт үүрэг болгосугай.


ДАРГА



Ж.ГАНБОЛД

1150500157

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын даргын
2016 оны *11* сарын *06*-ны өдрийн
А.Б. дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



“Улаанбаатар марафон-2016” олон улсын
гүйлтийн азтануудыг шагналыг төсөв

№	Зардлын нэр	Нийт дүн /төг/
1.	4 хүн x 500.000 төг	2.000.000 төг
2.	6 хүн x 100.000 төг	600.000 төг
3.	1 хүн 1.000.000 төг	1.000.000 төг
ДҮН:		3.600.000 төг

Боловсруулсан:
Мэргэжилтэн

Б.Түвшинбаяр

Хянасан:
Нягтлан бодогч

О.Эрдэнэцэцэг

Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хорооны
даргын 2016 оны *12* сарын *06*-ны өдрийн
А/Ж дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



“Улаанбаатар марафон-2016” олон улсын
гүйлтийн азтануудын нэрс

- | | |
|----------------------------|----------|
| 500.000 төгрөгийн азтанаар | |
| 1. Сүхбаатар Алтангэрэл | C1-00446 |
| 2. Тэгшээ Адьяацэрэн | D4-17445 |
| 3. Навчаа Ууганхишиг | D3-09803 |
| 4. Болдхуяг Болдбаяр | D3-12573 |
| 100.000 төгрөгийн азтанаар | |
| 5. Бямбасүрэн Золжаргал | D4-13235 |
| 6. Жигжид Баярцэнгэл | D8-22680 |
| 7. Ундрах Мягмарсүрэн | D4-16501 |
| 8. Цогтбаатар Гантулга | C1-00592 |
| 9. Ишдорж Бүжидмаа | D4-17913 |
| 10. Бат-Өлзий Аззаяа | D7-17490 |
| 1.000.000 төгрөгийн азтан | |
| 11. Дамбадаржаа Гантулга | B1-00585 |